# ДОРНОД АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв /мян.төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| ***Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт*** | | | | | | | |
| *“Нийгмийн даатгалын хууль тогтоомж, нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан (актуар) тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах, нийгмийн хамгааллын чиглэлээр байгуулсан олон улсын хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах”* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 1.1. | Нийгмийн даатгалын багц хууль болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах; | Шаард-лагагүй | Хэрэгжүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо | Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой НДЕГ-аас ирүүлсэн 12 удаагийн зөвлөмжийн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан. | Дээд газраас ирүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажилласан байна. | Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль. Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх зөвлөмжийн дагуу тэтгэвэр тогтоох ажиллагаа зохион байгуулж ажиллаж байна. Үүнд:<br>Хууль тогтоомжийн өөрчлөлт шинэчлэлт-тэй холбоотой 16 чиглэл заавар зөвлөмж ирснийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>-Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5.1.1-д нөхцлөөр 2025 онд нийгмийн даатгалын шимтгэлийг 22 жил ба түүнээс дээш хугацаанд төлсөн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эрэгтэй 60 нас, эмэгтэй 55 нас хүрсэн даатгуулагч өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгож байна. Мөн 10-аас доошгүй жил шимтгэл төлсөн даатгуулагч эмэгтэйд төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авсан хүүхдийн тоогоор 1 жил 6 сарыг нэмэгдүүлэн тооцож тэтгэвэр тогтоож байна.<br>- Цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгох алба хаагчид нийгмийн даатгалын шимтгэл төлсөн 1 жилийн хугацааг 6 сар цэргийн алба хаасанд тооцон тэтгэврийг нэмэгдүүлэн тооцож байна. Засгийн газрын 2024 оны "Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай" 221 дүгээр тогтоолоор нийт тэтгэврийн хэмжээг 6 хувиар нэмэгдүүлэн олгож байна. Бүрэн тэтгэврийн доод хэмжээ 689000 төгрөг, хувь тэнцсэн тэтгэврийн доод хэмжээ 572400 төгрөгт болж, дундаж тэтгэврийн хэмжээ ӨНТ-837558 төг, ХБИТ- 623531 төгрөг, ТАТ-666762 төгрөгт хүсэн байна.<br>- Монгол улс ОХУ-тай байгуулсан нийгмийн хамгааллын гэрээний дагуу 2 даатгуулагчид өндөр насны тэтгэвэр тогтоосон.<br>- Цэргийн албан хаагч нь Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгоход түүний алба хаасан хугацааны тэтгэврийн даатгалын шимтгэлийг тооцож нийгмийн даатгалын санд нөхөн төлөх заалтаар 3 даатгуулагчийн шимтгэлийг төлүүлэн тэтгэврийг тогтоолоо.<br>- Хуулийн 9 дүгээр зүйлийн тусгай зохицуулалтын хүрээнд 51 тэтгэвэр авагчийн тэтгэврийг 20 хувиар нэмэгдүүлэн олгож байна.<br><br>- Жирэмсэн амаржсаны тэтгэмж болон ажилгүйдлийн тэтгэмж бодох | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хугацаанд нийтээр амра өдөртэй адилтгах болсн хэмжээ нэмэгдсэн. ХЧТА-ь хувь хугацаанд өөрчлөлт сайжирсан. Жирэмсэн амаржсань хугацаанд ХЧТА бол тэ давхардуулан олгоно. |
| **Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт** | | | | | | |
| ***Зорилт 2:*** *"Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлын санхүүжилт, шимтгэлийн хөнгөлөлт тогтоосон хугацаанд олгох, өр барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажилла мөнгөжүүлсэн орлогыг тэтгэврийн нөөц санд байршуулах, нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд х хөрөнгийг нэмэгдүүлэх, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах"* ***гэсэн байгууллагын с хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | |
| 2.1. | Нийгмийн даатгалын сангаас болон ЦАХ-ийн тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан даатгуулагчийн мэдээллийг үүсгэж тэтгэврийг тогтоож, олгох | | Тогтоосон тэтгэврийн тоо, олгосон тэтгэврийн хэмжээгээр | Тэтгэвэр тэтгэмжийг хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой зөвлөмжийн хэрэгжүүлэн өмнөх оны дундажаар ажлыг | Зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажилласан байна. | Нийгмийн даатгалын Цэргийн албан хааг тэтгэмжийн тухай хуулийн Өндөр насны тэтгэвэр бэрхшээлтэй иргэдийн тэжээгчээ алдсаны тэтгэв тогтоогоод байна. зохицуулалтын тэтгэвэр олгосон байна. Нөхцлөөр тогтоолгосон тэ Шинээр тэтгэвэр тогтоос хөдөлмөрийн чадвар алда тэтгэвэр авагчдын тэтгэв удаа олгож байна. Дорнод аймгийн хэмжээнд хагаст давхардсан тоогс иргэдийн тэтгэвэр 813, ту 141/ тэтгэвэр авагчдад төгрөгийн тэтгэвэр олгосон<br>• Өндөр насны тэтгэв 51165,1 сая төгрөг |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр 2631 хүнд 9760,1 сая төгрөг<br>• Тэжээгчээ алдсаны тэтгэвэр 627 хүнд 2397,2 сая төгрөгийг тус тус олгосон.<br>• Улсын төсвөөс цэргийн 696 тэтгэвэр авагчид 6438,2 сая төгрөг,<br>• 1995 оноос өмнөх тэтгэвэр 694 тэтгэвэр авагчид 538,7 сая төгрөг,<br>ҮОМШӨ-ний даатгалын сангаас 58 тэтгэвэр авагчид 485,7 сая төгрөгийн тэтгэвэр олгоод байна. | |
| 2.2 | Тэтгэврийн өөрчлөн тогтоолт болон шилжилт хөдөлгөөнийг бүртгэн тэтгэврийн олголтын тооцоог хийх | | Шилжилсэн тэтгэвэр авагч, өөрчлөн тогтоосон тэтгэврийн тоо, олгосон тэтгэврийн хэмжээгээр | Тэтгэвэр тэтгэмжийг хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой зөвлөмжийн хэрэгжүүлэн өмнөх оны дундажаар ажлыг | Зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажилласан байна. | Шимтгэл төлж ажилласан хугацаагаа нэмүүлэн 112 тэтгэвэр авагч тэтгэврээ өөрчлөн тогтоолгосон байна.<br>Шилжиж явсан-9, Шилжиж ирсэн-24, Нас барсан-138, Зогсоогдсон-106 тэтгэвэр авагчийн хөдөлгөөнийг мэдээллийн санд бүртгэн, нас барсан тэтгэвэр авагчдын дараа сарын тэтгэврийг тухайн сард олголоо.<br>Хөдөлмөрийн чадвар алдсан 445 тэтгэвэр авагчийн хувь хугацааны мэдээллийг ЭММЗ-ийн программаас татан сунгалтыг хийж 7 хоног бүр тэтгэврийг нэмэлтээр олгож байна.<br>Мөн тэтгэвэр авагч нь үйлчлүүлэх банкаа өөрөө сонгох эрхийн дагуу 558 тэтгэвэр авагч шилжсэн байна.<br>Тэжээгч алдсаны хуваагдсан тэтгэвэр авдаг 8 тэтгэвэр авагчийн олголтын банкинд тусгай жагсаалтаар олгож, шүүхийн шийдвэрийн дагуу суутгал хийдэг 5 тэтгэвэр авагчийн бодогдсон тэтгэврийн 50 хувийг аймгийн ШШГГ-ын дансанд шилжүүлж байна. | |
| 2.3 | Ажил олгогч, даатгуулагчаас илгээсэн хүсэлтийн дагуу хөдөлмөрийн чадвар түр алдсаны болон жирэмсэн | | Нийгмийн даатгалын сангийн 2024 оны орлого, зарлагын гүйцэтгэл | Нийгмийн даатгалын санд өмнөх онд орлого төвлөрүүлж, | Батлагдсан төсвийн хуваарь, дээд газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг | Ажил олгогч даатгуулагчаас илгээсэн ХЧТА-1415 даатгуулагчид 762.1 сая төгрөг, жирэмсэн амаржсаны тэтгэмжийг 503 даатгуулагчид 2077.6 сая төгрөгийг тэтгэмжийн даатгалын сангаас олгосон. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | амаржсаны тэтгэмжийг тогтоож, олгох | | | тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардалд .... төгрөг зарцуулсан. | мөрдөж ажилласан байна. | Мөн сэргээн засах сувиллын зардлыг 1 даатгуулагчид 0.5 сая төгрөг, ХЧТА-ны тэтгэмжийг 34 даатгуулагчид 43.6 сая төгрөг, сувиллын унааны зардлыг 3 даатгуулагчид 0.8 сая төгрөгийг ҮОМШӨ-ний даатгалын сангаас олгоод байна. | |
| 2.4 | Даатгуулагчаас илгээсэн хүсэлтийн дагуу ажилгүйдлийн тэтгэмжийг тогтоож, олгох | | Нийгмийн даатгалын сангийн өмнөх оны орлого, зарлагын гүйцэтгэл | Нийгмийн даатгалын санд төвлөрүүлж, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардалд ... төгрөг зарцуулсан. | Батлагдсан төсвийн хуваарь, дээд газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг мөрдөж ажилласан байна. | Ажилгүйдлийн даатгалын сангаас 323 даатгуулагчид 2048.4 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг олгоод байна. Мөн ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж авч буй даатгуулагч тэтгэмжийн хугацаа дуусаагүй байхад ажилд орсноос илүү олгосон тэтгэмжийг буцаан төлүүлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд тус санд 21 иргэний ажилд орсон тушаалыг авчрууллж тооцоо хийн 13 иргэний 13.5 сая төгрөгийг ажилгүйдлийн даатгалын санд буцааж төлүүлсэн ба тэтгэмж олгох хугацаа дуусгавар болсон буюу тооцоо дууссан даатгуулагчийн ажилгүйдлийн тэтгэмжийн хувийн хэрэгт тэмдэглэл хөтөлж ажиллалаа. Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн өрөөс шалтгаалан 7 даатгуулагчийн 12.7 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг түр хугацаагаар хойшлуулаад байна. | |
| 2.5 | Даатгуулагч нас барагчийн ар гэрт олгох тэтгэмжийг тогтоож, олгох | | Холбогдох хууль тогтоомжийн дагуу мэдээллийг үнэн зөв бүртгэнэ. | Нийгмийн даатгалын мэдээллийн санг тухайн үед нь засварлах | а) Анхан шатны бүртгэлийг цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэх ажлыг зохион байгуулж, бүртгэлийн алдаа, залруулга гаргахгүй байх.<br>б) Даатгуулагчийг үнэн зөв бүртгэж мэдээллийн сан бүрдүүлсэн байна | Нийгмийн даатгалын санд 36-аас доошгүй сар шимтгэл төлсөн даатгуулагчид тэтгэмжийн даатгалын сангаас нас барагчийн ар гэрт олгох хуулийн дагуу тэтгэмжийг 181 даатгуулагчийн ар гэрт 362,0 сая төгрөгийг олгосон байна.<br>Үүнээс 138 нь нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авч байсан байна. | |
| 2.6 | Нийгмийн даатгалын сангийн цахим мэдээллийн санг тухай бүр үнэн зөв бүрдүүлэх. | | | | | а) Нийгмийн даатгалын санд бүртгэгдсэн тэтгэвэр авагч, даатгуулагчийн регистрийн дугаар хаяг, банкны дансны дугаарыг үндсэн баримт бичигтэй тулгаж засварлах,<br>б) Нийгмийн даатгалын мэдээллийн шинэчилсэн Core системд тэтгэвэр авагчдын гар олголтыг нэг бүрчлэн банкны | |

<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td>гүйлгээтэй тулган мэдээллийг үнэн зөв бүртгэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.</td><td></td></tr>
<tr><td>2.7</td><td>Нийгмийн даатгалын сангийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, санхүүгийн тайлан гаргах,</td><td></td><td>Сангийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг үнэн зөв гаргана.</td><td>Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан гүйцэтгэлийн сарын мэдээг гаргаж, ирүүлсэн.</td><td>Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан гүйцэтгэлийн сарын мэдээг үнэн зөв гаргасан байна.</td><td>Банкинд гар жагсаалтаар олгосон 4054 тэтгэвэр авагчдын олголтын хуваарийг үүсгэн мэдээллийг санд нөхөж оруулан 2024 оны тэтгэврийн тайланг гаргалаа.<br>Мөн сар бүрийн сангийн гүйцэтгэлийн мэдээг нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэл, тайлангийн системээр хугацаанд нь гаргаж хүргүүлсэн. Сар бүрийн тэтгэвэр, тэтгэмжийн гүйцэтгэлийн мэдээ тайланг Санхүү бүртгэл хамралт орлогын хэлтэстэй тулган ажилласан байна.</td><td></td></tr>
<tr><td colspan="8">Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт</td></tr>
<tr><td colspan="8">“Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:</td></tr>
<tr><td colspan="8">Зорилт 3.1: “Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагч, иргэн болон нийгмийн даатгалын орон нутгийн нэгжид хяналт шалгалт хийж шийдвэр гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:</td></tr>
<tr><td>3.1.1</td><td>Тэтгэвэр, тэтгэмжийн тогтоолт, олголтод тавих хяналтыг сайжруулах</td><td></td><td>Тэтгэвэр, тэтгэмжийн илүү дутуу олголтгүй ажилласан байна.</td><td>Илрүүлсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг тайлант хугацаанд барагдуулах,</td><td>Тэтгэвэр, тэтгэмжийн илүү, дутуу олголтыг бууруулсан байна.</td><td>Тэтгэвэр олголтод тавих хяналтаар тэжээгчээ алдсан 3, хөдөлмөрийн чадвараа алдсаны 3, өндөр насны 1 нийт 7 тэтгэвэр авагчид илүү олгосон 9.4 сая төгрөгийг илрүүлэн тэтгэврийн даатгалын санд төлүүлсэн. Үлдэгдэл төлбөрийн тэтгэвэр авагчтай тохирон хуваарь гарган төлүүлэхээр ажиллаж байна.<br>Тэтгэвэр тогтоолтын баримт бичгийн бүрдэлд хүүхдийн гэрчилгээний хуулбар болон 1990-1994 оны малчин байсан хугацааны сум, баг, хорооны засаг даргын тодорхойлолт шаардлага хангахгүй ирж байна. Малчны тодорхойлолт, “А” дансны лавлагааны үндэслэлийг хянан, баталгаажуулах, хүүхдийн гэрчилгээний лавлагаа дээр үрчилсэн, нас барсан шалгааныг хянах боломжгүй тул өргөдлийн</td><td></td></tr>
</table>

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | маягтад тусгагдсан хүүхдийн мэдээллийг үнэн зөв бөглөсөн байх шаардлага тавин ажиллаж байна.<br>Мөн ДБЭХС-ын зарим ажиллагсдын албан тушаал ХНХ-ын сайдын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/221 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан ажил мэргэжлийн жагсаалтаас зөрүүтэй бичигдсэн хортой нөхцөлийн тэтгэврийг албан тушаалын тодорхойлолттой тулган 3 хүсэлтийг шийдвэрлэсэн байна. Хэвийн бус нөхцөлд ажиллагсдын ажил мэргэжлийг тушаал шийдвэрт зөв тусгах талаар ДБЭХС ТӨХК, Степ голд ХХК-ийн санхүү, хүний нөөц, хуулийн мэргэжилтнүүдэд зөвлөгөө өглөө. | |
| 3.1.2 | Тэтгэвэр авагчдын хувийн хэрэг, хавсаргасан баримтыг тэтгэвэр авагчдын жагсаалттай тулган тооллого явуулах, | | Тооллого, хяналт шалгалтыг хийж, холбогдох арга хэмжээ авч ажилласан байна. | Тооллогоор 15211 тэтгэвэр авагчийн хувийн хэрэг бүрэн хамрагдсан. | Тэтгэвэр авагчдын хувийн хэргийн хадгалалт, хамгаалалт сайжирсан байна. | Хэрлэн сумаас бусад сумдын тэтгэвэр авагчдын 6564 хувийн хэргийг бүрэн тоолж дууссан. Тооллогоор хувийн хэрэг дутагдаагүй байна. Хэрлэн сумын 8810 тэтгэвэр авагчдын хувийн хэргийн тооллогыг 6 сард багтаан тоолохоор төлөвлөөд байна. | |
| 3.1.3 | Хяналт шалгалтаар илэрсэн болон нийгмийн даатгалын улсын байцаагчийн акт, албан шаардлагын биелэлтийг хангуулах, | | Өмнө нь гарч байсан алдааг дахин давтан гаргахгүй байна. | - | Актын төлбөрийг бүрэн барагдуулсан байна. | НДЕГ-ын 2024 оны шалгалтаар илэрсэн зөрчилд тавьсан актын дагуу 10 тэтгэвэр авагчид илүү олгосон 24,7 сая төгрөгийн зөрчлийн 9 тэтгэвэр авагчийн 4,86 сая төгрөгийг тэтгэврийн даатгалын санд төвлөрүүлээд байна. Мөн дотоод хяналт шалгалтаар 2024 оны тэтгэврийн олголт, шилжилт хөдөлгөөн, нас баралтад шалгалт хийж 7 тэтгэвэр авагчид холбогдох 9.4 сая төгрөгийн илүү олголт, илрүүлэн буцаан төлүүлээд байна.<br>Нийгмийн даатгалын улсын ахлах байцаагчийн 32/00004 дугаар албан шаардлагад заасны дагуу ХНХ-ын сайдын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/221 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Тэтгэврийг хөнгөлөлттэй нөхцлөөр тогтоох, газрын доор, | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөдөлмөрийн хортой, ха<br>хамаарах ажил мэргэж<br>мөрдөн ажилла<br>Нийгмийндаатгалын дэв<br>жагсаалтаас зөрүүтэй б<br>тэтгэврийг албан тушаал<br>хөдөлмөрийн гэрээ<br>баримтыг үндэслэн<br>хүсэлтийг шийдвэ<br>Шаардлагатай тохи<br>дэргэдэх "Маргаан хя<br>зөвлөл"-өөр хэлэлцүүл<br>байна. Хэвийн бус нөхц<br>ажил мэргэжлийг тушаал<br>тусгах талаар ДБЭХС<br>ХХК-ийн санхүү, хүни<br>мэргэжилтнүүдэд зөвлөг<br>Мөн Нийгмийн даатгалы<br>21 дүгээр зүйлийн 21.<br>хаагчийн тэтгэвэр, т<br>хуулийн 22 дугаар зүй<br>хаагчийн тэтгэвэр, тэтгэм<br>нэмэлт, өөрчлөлт оруул<br>дагаж мөрдөх журмын<br>дугаар зүйлд заасны да<br>хаагчийн 1995 оноос<br>ногдох тэтгэврийн даат<br>Засгийн газрын 2023<br>тогтоолын хавсралт<br>"Нийгмийн даатгалын ш<br>тооцогдох хугацаанд ни<br>шимтгэл төлөх журам"-<br>заасны дагуу тооцон<br>тэтгэврийн даатгаль<br>төлүүлэхээр нэхэмжлээд |

**Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт.**

***Зорилт 4.1:*** *"Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах"* ***гэсэн байгууллагын хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:***

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.1 | Иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг тайлагнах; | - | -Өргөдөл шийдвэрлэлтийг 100% хугацаанд нь, үнэн зөв, бодит үр дүнтэй шийдвэрлэсэн байна. | Иргэд, байгууллагаас ирсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэлтийн түвшин салбарын хэмжээнд 2024 онд 98%-тай хэрэгжсэн байна. | Өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд бүрэн барагдуулж, шийдвэрлэлтийн мэдээг үнэн зөв гаргаж, хүргүүлсэн байна. | Тэтгэвэр шинээр тогтоолгох болон өөрчлөн тогтоолгох 1035, тэтгэмж авахыг хүссэн 2308 хүсэлтийг хүлээн авч 98,14 хувийг шийдвэрлээд байна. Өндөр насны тэтгэврийн анх тогтоолгосон цалинг өөрчлөн тогтоолгох 1 /амралтын цалин хуваах/, нийгмийн даатгалын шимтгэлийн өр үүсгэсэн ажил олгогчдоос шалтгаалан хөдөлмөрийн чадвар түр алдсаны болон ажилгүйдлийн тэтгэмжийг олгуулах тухай 35 хүсэлтийг шийдвэрлэгдээгүй байна. | |
| 4.1.2 | Дээд байгууллагаас өгсөн хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүр нь хүргүүлж ажиллах; | - | -Хугацаанд нь хүргүүлэх,<br>-Баримтын чанар, үзүүлэлт тодорхой байна. | Нийгмийн даатгалын ерөнхий газраас өгсөн үүрэг даалгавар, албан бичиг, шийдвэрийг цаг хугацаанд нь ирүүлсэн байна. | Үүрэг даалгавар, албан бичиг, шийдвэрийг цаг хугацаанд нь хэрэгжүүлж, биелэлтийг заасан хугацаанд хүргүүлнэ. | “Журам, заавар, өргөдлийн маягтын загвар батлах тухай” НДЕГ-ын даргын 2024 оны А/246 дугаар тушаалыг хэрэгжүүлэн Тэтгэвэр тогтоолгох, баримт бичгийн бүрдэлд хяналт тавих хувийн хэрэг бүрдүүлэх бүртгэх журмыг баримтлан тэтгэврийг тогтоож хувийн хэргийг бүрдүүлэн батлагдсан өргөдлийн загварыг хэрэглэх зэргээр хяналт тавин ажиллаж байна. Мөн Тэтгэвэр бодох зааврын дагуу 2025 онд хэрэглэх цалин хөлсний итгэлцүүрийг баримтлан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, Цэргийн албан хаагчийн тэтгэврийг тооцож зохих шатны хяналтуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>Мөн 2025 оны 01 дүгээр албан даалгаврын дагуу ажилтан албан хаагчдын сахилга хариуцлага, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэн дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тэтгэвэр тэтгэмжийн тогтоолт, илүү дутуу олголтын тооцоог тухай бүр хийж ажиллаж байна | |
| 4.1.3 | Даатгуулагчдаас сэтгэл ханамжийн судалгаа авч үр дүнг хагас жил тутам Нийгмийн даатгалын газрын даргын зөвлөлд танилцуулах; | - | Сэтгэл ханамжийн судалгаа 2 удаа хийгдсэн байна. | - | Иргэд, даатгуулагчийн сэтгэл ханамжийг судалгааны үр дүнг улирал бүр гаргаж танилцуулна. | Нийгмийн даатгалын хууль тогтоомж, цахим үйлчилгээний талаар мэдлэг мэдээллийг тандах үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр даатгуулагчид, тэтгэвэр авагчдаас тогтмол судалгаа авах зорилгоор сэтгэл ханамжийн судалгааны асуултыг боловсруулан ажиллаж байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.4 | Байгууллагын үйл ажиллагааг сайжруулах албан хаагчдын бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой, шинэлэг ажил зохион байгуулах, | | Үйлчилгээг сайжруулах, төсвийн хөрөнгийг хэмнэсэн, санал санаачлага өрнүүлэн үр дүнд хүрсэн байна. | Шинэлэг ажил үйлчилгээ нэвтрүүлж эхэлсэн байна | Шинэлэг ажил үйлчилгээ нэвтрүүлсэн байна | Төрийн албаны бүтээмжийг нэмэгдүүлэх байгууллагын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр тодорхой, шинэлэг ажил зохион байгуулах талаар гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулаад байна. Одоогоор тодорхой шинэ санаа дэвшүүлж хэрэгжүүлээгүй байна. | |
| ***4.2*** *Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, олон нийт, харилцагч байгууллага салбар хэлтэс, тасгуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах* | | | | | | | |
| 4.2.1 | Нийгмийн даатгалын байгууллагын ажилтны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах; | | Хүний нөөцийг чадавхижуулах чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо, хамруулсан хүний тоо | Албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх .... удаагийн сургалтад ...... албан хаагчийг хамруулсан. | -Албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх танхимын болон цахим сургалт зохион байгуулна.<br>-Шинэ ажилтныг ажлын байран дээр дадлагажуулах сургалт зохион байгуулж, хөрвөх чадвар бүхий мэргэжилтэн бэлтгэнэ. | НДЕГ-аас Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн систем Сикос системд шилжсэнтэй холбогдууланн дэд системүүд дээр хэрхэн ажиллах талаар нийт байцаагч нар болон тэтгэвэр, тэтгэмж, орлого шимтгэлийн байцаагч, үйл ажиллагааны нягтлан бодогч нарт сургалт хийлээ.<br>Мөн аймгийн татварын газраас ХХОАТ-ыг цахимаар илгээх, төрийн албан хаагчдын "Монгол бичгийн мэдлэг дээшлүүлэх" сургалт, жендерийн төвөөс "Харилцан хүндэтгэе", "Кибер аюулгүй байдлын эрх зүйн орчин", "Нийгмийн түншлэл ба хөдөлмөрийн эрх", Төрийн албан хаагчийн хөгжил, хамгаалал"-ын талаар нийт 27 удаагийн сургалтад давхардсан тоогоор 216 албан хаагч оролцож мэдлэг ур чадвараа дээшлүүллээ. | |
| 4.2.2 | Хэлтсийн байцаагч ажилтнууд авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх сургалтыг зохион байгуулах; | | -Авлигаас урьдчилан сэргийлэх 2 удаагийн сургалт зохион байгуулах,<br>-Нийт албан хаагчдыг 100% хамруулсан байна. | Авлигын тухай, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар 2 удаагийн | Ажилтнууд авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг дээшилж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана. | Авлигатай тэмцэх газраас авлига ашиг сонирхоос урьдчилан сэргийлэх болон соён гэгээрүүлэх чиглэлээр зохион байгуулж буй цахим сургалтад эрх бүхий албан тушаалтан болон нийт албан хаагчдыг тогтмол хамруулж байна.<br>Мөн өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан ТЗ-7 шатлалаас дээш албан хаагчдад ХАСХОМ, ХАСУМ мэдүүлэх, тайлагнах талаарх сургалтыг авч мэдүүлгийг хугацаанд цахим мэдээллийн санд байршуулсан. Мөн соён гэгээрүүлэх урьдчилан сэргийлэх мэдээллүүдийг цахим | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | сургалтыг зохион байгуулсан. | | орчинд байршуулснаар ажилтнууд эрсдлээс өөрийгөө болон хамт олноо хамгаалахад суралцан ажиллаж байна. | |
| ***Зорилт 4.3:*** *"Нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх, сайжруулах, цахим, нэг цэгийн болон явуулын хэлбэрээр нийгмийн даатгалын үйлчилгээг явуулах, олон нийт, харилцагч болон харьяа байгууллагуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах"* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 4.3.1 | Даатгуулагч, иргэдийн нийгмийн даатгалын талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулах; | | - Даатгуулагчид чиглэсэн сургалтыг өмнөх оноос 10-аас доошгүй хувиар нэмэгдүүлэх,<br>- Иргэд, даатгуулагчдын 10-иас доошгүй хувийг хамруулсан байна. | Иргэд, даатгуулагчид чиглэсэн 12 удаагийн сургалтад 682 иргэд, даатгуулагчийг хамруулсан. | Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн талаар сургалт, арга хэмжээг зохион байгуулж, иргэд даатгуулагчийг хамруулсан байна. | Орон нутгийн 14 хоног тутам хэвлэгддэг "Дорнод" сонинд Нийгмийн даатгалын ач холбогдол, хуулийн шинэчилсэн найруулга, нийгмийн даатгалын цахим үйлчилгээ, үйл ажиллагааны талаар болон цаг үеийн мэдээлэл бэлдэн 10 удаагийн дугаарт хэвлүүлсэн байна<br>Оны эхнээс Нийгмийн даатгалын газрын пейж хуудсанд 49 мэдээлэл бэлтгэн байршуулсан ба ХНХЯ-наас бэлтгэсэн 16, НДЕГ-аас бэлтгэсэн 61, ЭМДЕГ-аас бэлтгэсэн 12 мэдээллийг шейрлэн иргэд даатгуулагчдад түгээн сурталчилж ажиллаж байна.<br>Нийгмийн цогц үйлчилгээний хүрээнд сумдын байцаагч нар 738 малчинд нийгмийн даатгалын ач холбогдол, малчины сайн дурын даатгалын хөнгөлөлтийн талаар сурталчилан 140 гаруй малчины тэтгэвэр тогтоолгох баримт бичгийг үзэж, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан байна.<br>Нийгмийн даатгалын газрын пейж хуудаснаас гадна харилцагч ажил олгогчдын, сайн дурын даатгуулагчдын болон сум бүрийн нийгмийн даатгалын фейсбүүк хаягийг ажиллуулан харилцан мэдээлэл солилцох ажлыг эрчимжүүлэн дагагчдын тоог нэмэгдүүлж мэдээллийг түргэн шуурхай хүргэн ажиллаж байна. | |
| 4.3.2 | Иргэд, даатгуулагчдад утсаар (CallPro) мэдээлэл зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах; | | Дуудлага алдалт 10% ба 15%-аас хэтрүүлэхгүй ажилласан байна | 1500 дуудлага | Иргэд, даатгуулагчдад утсаар зөвлөгөө мэдээллийг шуурхай | Иргэд, даатгуулагчдад (CallPro) үйлчилгээний 70585955 дугаарын утсаар нийгмийн даатгалын үйл ажиллагааны талаар мэдээлэл өгч ажил олгогчийн | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | өгч, ажилласан байна. | тайлан, сайн дурын да төлөлт, тэтгэвэр, тэтг олголтын талаар мэдээл ажиллаж байна. Дуудла хувиар бууруулан |
| 4.3.3 | Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагаа, үйлчилгээг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах, | | Цахим мэдээл-лийн хэрэгслээр сурталчилгаа хийх,<br>-"Постер" сард 2-аас доошгүй удаа;<br>- Хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан мэдээ мэдээлэл өгөх, улирал бүр; | Нийгмийн даат-галын хууль тогтоомж, үйл ажиллагаа, үйлчилгээг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлаж, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажилласан байна. | Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйлчилгээ, үйл ажиллагааг сурталчилсан сурталчилгаа бэлтгэж түгээх. Нийгмийн даатгалын ерөнхий газрын пэйж хуудсаар нийтэлсэн мэдээ мэдээллийг тогтмол түгээж ажилласан байна. | Орон нутгийн 14 хоног "Дорнод" сонинд Нийгмі холбогдол, хуулийн шинэ нийгмийн даатгалын цах ажиллагааны талаар б мэдээлэл бэлдэн 10 хэвлүүлсэн байна<br>Оны эхнээс Нийгмийн , пейж хуудсанд 49 м байршуулсан ба ХНХЯ-н НДЕГ-аас бэлтгэсэн бэлтгэсэн 12 мэдээллиі даатгуулагчдад түгэ: ажиллаж байна.<br>Нийгмийн цогц үйлчи сумдын байцаагч на| нийгмийн даатгалын малчины сайн ду хөнгөлөлтийн талаар гаруй малчины тэтгэвэр бичгийг үзэж, зөвлөгө ажилласан байна.<br><br>Нийгмийн даатгалын хуудаснаас гадна олгогчдын, сайн дуры болон сум бүрийн ниі фейсбүүк хаягийг ажил мэдээлэл солилцох аж дагагчдын тоог нэмэгд түргэн шуурхай хүргэн а: |

***Зорилт 4.4:*** *"Нийгмийн даатгалын харилцаанд оролцогч талуудад эрүүл мэндийн магадлалын чиглэлээр мэргэжил арга зүйн*
***байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:***

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.4.1 | Эрүүл мэндийн магадлалын талаарх хууль тогтоомжийн биелэлтийг хангаж ажиллах | | Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шалтгаан шийдвэрлүүлж буй иргэдийн оношийн баталгаажилтад жилд 4-өөс доошгүй удаа хяналт хийсэн байна. | Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр сурталчилгаа хийсэн ....... тоо, мэдээллийн төрөл..... | Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээ болон бусад хэлбэрээр олон нийтэд ойлгомжтой, шуурхай хүргэсэн байна.<br>ХНХЯ болон НДЕГ-аас бэлтгэсэн мэдээллийг бүх албан хаагчдаар цааш түгээлгэж, олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан байна. | Засгийн газрын 2023 оны 448 дугаар тогтоолын хавсралтаар шинэчлэн баталсан “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм”-ийн дагуу холбогдох байгууллагуудаас зөвлөлийн бүрэлдэхүүнд ажиллах мэргэжилтнүүдийн саналыг албан бичгээр авч нэгтгэн, ерөнхий газарт хүргүүлсэн. Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөл нь Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны А/38 дугаар тушаалаар баталсан 10 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн зохион байгуулагдаж 46 удаагийн хурлаар нийт 2728 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг шийдвэрлэсэн байна. Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн хурлаар иргэдийн оношийн баталгаажилтыг төрөлжсөн мэргэжлийн эмч нар тогтмол хянаж, оношийн бүрдэл дутуу, баталгаажилт хангалтгүй, хяналтын үзлэг хангалтгүй зэрэг 48 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг түдгэлзүүлсэн байна.<br>Хурлын үед хийгдсэн хөдлөгөөний мэдээллийг хянаж эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн app.ndaatgal.mn.ehmkweb програмд файлаа хугацаанд тогтмол илгээж хэвшээд байна. | |
| | | | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн мэдээллийн цахим сангийн бүрдүүлэлтэд хагас жил тутам | Зохион байгуулсан ажлын тоо, тайланг ЭММТЗ-д хүргүүлсэн байна. | Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шалтгаан шийдвэрлүүлж буй иргэдийн оношийн баталгаажилтад хяналт хийж холбогдох арга | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн 46 удаагийн хурлаар шийдвэрлэсэн нийт 2728 иргэний мэдээллийг зөвлөлийн мэдээллийн санд үнэн, зөв бүрдүүлсэн эсэхэд тухай бүр хяналт тавьж ажиллав. Хяналтын явцад хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа, сунгалтын он сар өдөр, оношийн код буруу 12, өвчний ангилал буруу 4 тохиолдолыг тус тус | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тулгалт хийсэн байна. | | хэмжээ авсан байна. | илрүүлэн, залруулах арга хэмжээ авав. Түүнчлэн тэтгэвэр авагчдын массивыг, зөвлөлийн хурлын мэдээллийн сантай тулган шилжиж явсан 18, шилжиж ирсэн 6, нас барсан 59, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн жил буруу 3 иргэний хөдөлгөөнийг засч бүртгэлийг шинэчлэн засварласан байна.<br>Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шийдвэрлэсэн байдлыг өвчний ангилалаар авч үзэхэд сэтгэцийн эмгэг, дотор, гэмтэл согог, нүд, чих хамар хоолойн өвчин нийт тогтоолтын 83.5 хувийг эзэлж байна | |
| 4.4.2 | Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагааны чанар хүртээмжийг сайжруулах арга хэмжээ зохион байгуулсан байх | | Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд тавих дотоод хяналт, шалгалтыг хагас жил тутам зохион байгуулж, үр дүнг тооцсон байна. | Зохион байгуулсан ажлын тоо, тайланг ЭММТЗ-д хүргүүлсэн байна. | Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд тавих дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулж, үр дүнг тооцсон байна. | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн 46 удаагийн хурлаар шийдвэрлэсэн нийт 2728 иргэний мэдээллийг зөвлөлийн мэдээллийн санд үнэн, зөв бүрдүүлсэн эсэхэд тухай бүр хяналт тавьж ажиллав. Хяналтын явцад хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа, сунгалтын он сар өдөр, оношийн код буруу 12, өвчний ангилал буруу 4 тохиолдолыг тус тус илрүүлэн, залруулах арга хэмжээ авав.<br>Түүнчлэн тэтгэврийн массивыг, зөвлөлийн хурлын мэдээллийн сантай тулган шилжиж явсан 18, шилжиж ирсэн 6, нас барсан 59, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн жил буруу 3 иргэний хөдөлгөөнийг засч бүртгэв. | |
| | | | Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд оролцогчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, ижил мэргэжилтний үзлэгийг 2-оос доошгүй удаа | | Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд оролцогчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, ижил мэргэжилтний үзлэгийг зохион байгуулж эмч, эмнэлгийн | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж буй асуудлыг хянах явцад оношийн үндэслэл хангалтгүй, дахин үзлэг, шинжилгээ хийлгэх шаардлагатай 3 иргэнд сэтгэцийн болон зүрх судасны төрөлжсөн мэргэжлийн ижил мэргэжилтэний үзлэгийг хийлгэж, дүгнэлтийг үндэслэн хөдөлмөрийн чадвар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | зохион байгуулсан байна. | | мэргэжилтнүүдийн ур чадвар сайжирч иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлэх үйл ажиллагаа ижил түвшинд хүрсэн байна. | алдалтын хувь, хугацааг сунгаж шийдвэрлэлээ. | |
| 4.4.3 | Эрүүл мэндийн магадлалын оролцогч талуудын үйл ажиллагааг нэгтгэн хэрэгжилтийг ханган ажиллах | Зохион байгуулалтын | Хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх, бууруулах жилийн төлөвлөгөө гарган, хэрэгжүүлэн ажиллана. | Төлөвлөгөөний хэрэгжилтийн болон судалгааны тайланг ЭММТЗ-д хүргүүлнэ. | Хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх, бууруулах төлөвлөгөө гарган, хэрэжүүлсэн байна. | Зөвлөлийн дотрын мэргэжилтэн хоол боловсруулах эрхтний эмгэгээс сэргийлэх дэлхийн өдрөөр нойр булчирхайн өөхжилт, оношилгоо, эмчилгээний менежментийн талаар 80 орчим эмчид мэдээлэл өгөв. Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн 110 бие бүрэлдэхүүнд "Зөв зохистой хооллолт" сэдвээр сургалт зохион байгууллаа. Чойбалсан хотын FM 89.1-д "Та элгээ гомдоосоор байх уу" сэдэвт олон нийтэд чиглэсэн ярилцлага өгсөн ба нийт 1000 орчим хүнд FM болон цахим сүлжээгээр хүрсэн байна.<br>"Тамхи таныг татна" сэдэвт сошиал контент бэлтгэн эрүүл мэндийн байгууллагын пэйж хуудсаар цацсан ба нийт 2.2 мянган үзэлттэй, 50 орчим шэйр хийгдэж 10 мянга орчим хүнд хүрсэн байна.<br>Дэлхийн зүрхний өдрөөр "Зүрхээ таньж зүрхээ хайрлая" сэдэвт сошиал контент бэлтгэн пэйж хуудсаар цацсан ба нийт 7.5 мянган үзэлттэй, 40 орчим шэйр хийгдэж 12 мянган орчим хүнд хүрсэн байна.<br>Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүн Зүүн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн мэдрэлийн их эмч эпилепси өвчтэй иргэд, тэдний ар гэр, асран хамгаалагч бүхий нийт 102 иргэнтэй уулзалт ярилцлага хийж, уг өвчний оношилгоо эмчилгээний талаар шинэ мэдээлэл өгч ажиллав. Эпилепси өвчний тухай гарын авлага, уналтын карт | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | боловсруулж иргэдэд тараав. Энэхүү өдөрлөгт БОЭТ-ийн эмчилгээ эрхэлсэн орлогч захирал, хүүхдийн мэдрэлийн, сэтгэцийн, гэмтлийн эмч нар хамтран оролцсон байна. | |
| | | | Хөдөлмөрийн чадвар алдалтын харьцуулсан судалгаа хийж, тодорхой арга хэмжээ авч орон нутгийн удирдлага, холбогдох байгууллагад танилцуулсан байна. | | Орон нутгийн иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд суурь болон харьцуулсан судалгааг хийж дүгнэсэн байна. | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүн Зүүн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн мэдрэлийн их эмч эпилепси өвчтэй иргэд, тэдний ар гэр, асран хамгаалагч 102 иргэнтэй уулзалт ярилцлага хийж, уг өвчний оношилгоо эмчилгээний талаар шинэ мэдээлэл өгч ажиллав. Эпилепси өвчний тухай гарын авлага, уналтын карт боловсруулж иргэдэд тараав. Энэхүү өдөрлөгт БОЭТ-ийн эмчилгээ эрхэлсэн орлогч захирал, хүүхдийн мэдрэлийн, сэтгэцийн, гэмтлийн эмч нар хамтран оролцсон байна. | |
| 4.4.4. | Эрүүл мэндийн магадлалын талаарх хууль тогтоомжийн талаар болон авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулах | Зохион байгуулалтын | Төрөлжсөн мэргэшлийн болон сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүдэд эрүүл мэндийн магадлалтай холбоотой хууль тогтоомжийн талаар болон авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр жилд 2-оос доошгүй удаа сургалт зохион байгуулсан байна. | Зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан хүний тоо, тайланг хүргүүлсэн байна.<br>Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр сурталчилгаа хийсэн ....... тоо, мэдээллийн төрөл..... | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн болон төрөлжсөн мэргэшлийн, сум, өрхийн Эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүдэд эрүүл мэндийн магадлалтай холбоотой хууль тогтоомжийн талаар сургалт зохион байгуулж шинэ мэдээ, мэдээллийг хүргүүлж ажилласан байна.<br>Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын | Төв зөвлөлөөс 2024 оны 05 дугаар сард ZOOM-оор зохион байгуулсан авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтад эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн 5 гишүүнийг хамруулав.<br>Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 448 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм”, Эрүүл мэнд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/441, А/192 дугаар хамтарсан тушаалын хавсралтаар баталсан “Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний жагсаалт”-ын талаарх мэдээллийг 2024 оны 01 дүгээр сард Зүүн Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Эрүүл мэндийн газарт Нийгмийн даатгалын газрын даргын 10, 11, 25 тоот албан бичгээр хүргүүлэв.<br>Түүнчлэн Зүүн БОЭТ, 3 өрхийн эрүүл мэндийн төвийн нийт 80 гаруй эмч | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Даатгуулагчийн төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхдийн мэдээллийг нягтлан хүлээн авсан байна. | программд оруулж, /portal.ndaatgal.mn/-д, нэвтрэх эрх олгон ажиллаж байна.<br><br>ЗХХ | |
| | | | | | Даатгуулагчаас цахимаар ирүүлэх баримтын бүрдэлийг бүрэн гүйцэд шаардаж авсан байна. | | |
| 4.5.2 | Байгууллагын хэмжээнд цахим шилжилтийг эрчимжүүлэх, төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэл, түүнд тавих хяналтыг сайжруулан программын ашиглалтыг нэмэгдүүлэх | Зохион байгуулалтын | Ирсэн, явсан бичгийн тоо | 100% | 100% | Нийгмийн даатгалын байгууллага нь иргэд, даатгуулагчдад үзүүлж буй нийгмийн даатгалын үйлчилгээний 65 хувийг цахимжуулан төрийн үйлчилгээний нэгдсэн систем E-Mongolia-д холбогдсон.<br>Мэдээллийн санг сайжруулах, байцаагч ажилтнуудын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор шинэ систем /Core/-ийг нэвтрүүлэн ажиллаж байна. Мөн ажил олгогч, даатгуулагчдад зориулсан Portal.ndaatgal.mn системээр нийгмийн даатгалын сангаас олгох бүх төрлийн тэтгэмжийн хүсэлтийг илгээх, лавлагаа авах, зөвлөгөө авах боломжтой болсон.<br>Цахимжуулалтыг эрчимжүүлснээр иргэд даатгуулагчид цаг хугацаа орон хамаарахгүй үйлчилгээ авах боломж бүрдэж байна.<br>Албан хаагчдын дунд ёс зүй-шударга байдал, авилгаас ангид хамт олон зэрэг сургалт сурталчилгааны ажлуудыг зохион байгуулж ажиллаж байна. | |

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГА И.ТӨГСБАЯР